



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 5 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 184

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Төрийн албаны тухай хуулийн 10.4, 18.8, 20.1, Төрийн албаны зөвлөлийн саналыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 275 дугаар тогтоолын хавсралтад дор дурдсан нэмэлт, өөрчлөлт оруулсугай:

1/ “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-ын “Төрийн захиргааны төв байгууллагын албан тушаал”-ын “Удирдах” албан тушаалын ТЗ-14 зэрэглэлд “3.Цөмийн энергийн комиссын Ажлын албаны дарга”, ТЗ-11 зэрэглэлд “5.Цөмийн энергийн комиссын Ажлын албаны нэгжийн дарга”, ТЗ-9 зэрэглэлд “5.Сав газрын захиргааны дарга”, ТЗ-7 зэрэглэлд “5.Сав газрын захиргааны албаны дарга” гэж, “Гүйцэтгэх” албан тушаалын ТЗ-8 зэрэглэлд “4.Цөмийн энергийн комиссын Ажлын албаны ахлах мэргэжилтэн” гэж, ТЗ-7 зэрэглэлд “6.Цөмийн энергийн комиссын Ажлын албаны мэргэжилтэн” гэж, ТЗ-6 зэрэглэлд “7.Сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн” гэж, ТЗ-5 зэрэглэлд “3.Сав газрын захиргааны мэргэжилтэн” гэж тус тус нэмсүгэй.

2/ “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-ын “Нутгийн захиргааны байгууллагын албан тушаал”-ын “Удирдах” албан тушаалын ТЗ-14 зэрэглэлд “3.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга”, ТЗ-13 зэрэглэлд “1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, 2.Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга”, ТЗ-10 зэрэглэлд “4.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны нэгжийн дарга”, ТЗ-9 зэрэглэлд “7.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны тасгийн дарга”, ТЗ-7 зэрэглэлд “6.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны нэгжийн дарга” гэж, “Гүйцэтгэх” албан тушаалын ТЗ-7 зэрэглэлд “4.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны ахлах мэргэжилтэн, “5.Улсын ахлах байцаагч, ахлах дотоод аудитор”, ТЗ-6 зэрэглэлийн “5.Улсын байцаагч” гэсний ард “,дотоод аудитор”, “10.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны ахлах мэргэжилтэн”, ТЗ-5 зэрэглэлд “11.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны ахлах мэргэжилтэн” гэж тус тус нэмсүгэй.

3/ Мөн хавсралтын “Нутгийн захиргааны байгууллагын албан тушаал”-ын “Удирдах” албан тушаалын ТЗ-13 зэрэглэлийн “1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга”, ТЗ-12 зэрэглэлийн “1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, 2.Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга” гэснийг, “Гүйцэтгэх” албан тушаалын ТЗ-6 зэрэглэлийн “3.Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн” гэсний “ахлах” гэснийг тус тус хассугай.

2. “Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”-ийн “Дүйцүүлэх албан тушаал”-ын ТҮЭМ-5 зэрэглэлд “3.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын их эмч” гэж, ТҮЭМ-4 зэрэглэлд “2.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын бага эмч” гэж тус тус нэмсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдон гарах нэмэлт зардлыг 2020 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх, цаашид жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг төсвийн захирагч нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Хөдөлмөр, нийгмийн
хамгааллын сайд

С.ЧИНЗОРИГ